

Хууль, эрх зүйн мэдээлэл #1

2026 оны 1 сар

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт 3.0

Хураангуй

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц Парисын хэлэлцээрийн зорилт болох дэлхийн дулаарлыг 1.5°C -д хязгаарлах хүрээнд талууд (улс орнууд) үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо батлах замаар уур амьсгалын бодлого, зорилтот арга хэмжээг тодорхойлон, хүчин чармайлтаа бэхжүүлэх үүрэг хүлээдэг. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 91 дугаар тогтоолоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг (“ҮТХН 3.0”) шинэчлэн баталсан байна. Монгол Улс хүлэмжийн хийн (“ХХ”) ялгарлыг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн тэргүүлэх салбаруудын тогтвортой хөгжлийг хангах, цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад үндэслэн өмнөх 2019 оны үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо ахиулан ҮТХН 3.0-г баталсан юм. ҮТХН 3.0-н дагуу Монгол Улс нь дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ нь:

- **Үндсэн зорилт (нөхцөлт бус):** 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшинтэй харьцуулахад 30.3 хувь бууруулах;
- **Хүлэмжийн хийн ойн шингээлтийг тооцсон зорилт:** 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн суурь түвшинтэй харьцуулахад 46.3 хувь бууруулах;
- **Үндсэн зорилт (нөхцөлт), хүлэмжийн хийн шингээлт, олон улсын дэмжлэгийг тооцсон дүнгээр:** 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн суурь түвшинтэй харьцуулахад 52.8 хувь бууруулах.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт, арга хэмжээ

ҮТХН 3.0-т хамгийн их ялгаруулагч тэргүүлэх 6 салбараар ХХ-н ялгарлыг бууруулахад чиглэсэн нөхцөлт бус арга хэмжээг тодорхойлсноос гадна өөрийн хүчин чармайлтаар хэрэгжүүлэх боломж одоогоор байхгүй боловч ХХ-н ялгарлыг бууруулахад ихээхэн нөлөө үзүүлэх нөхцөлт арга хэмжээг мөн тодорхойлсон. Энэхүү нөхцөлт арга хэмжээний нэг онцлог нь бэлчээртэй холбоотой арга хэмжээ юм. Учир нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 129,339,500 га талбай бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байгаа бөгөөд цөлжилт, газрын доройтол болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бэлчээрийн хөрсний нүүрстөрөгч шингээх чадвар алдагдаж байгааг олон жилийн судалгааны дүн нотолж байгаа юм. Дараагийн хуудаст нөхцөлт болон нөхцөлт бус арга хэмжээг салбар бүрээр тусгав.

Холбоо барих:

Серги Кобахидзе
Партнер
Татвар, Хуулийн үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал
Ахлах менежер, хуульч
Татвар, Хуулийн үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Чойжамцын Цэндмаа
Захирал
Татвар, Хуулийн үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Отгонтогтоолын Мөнхнасан
Ахлах хуульч
Татвар, Хуулийн үйлчилгээ
munkhnasan.otgontogtool@pwc.com

**Өмгөөллийн
ПрайсуотэрхаусКүүпэрс
Легал ХХН**

Сентрал Тауэр, 6 давхар
605 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт, арга хэмжээ

Салбар	Арга хэмжээ (нөхцөлт бус)	Арга хэмжээ (нөхцөлт)
Эрчим хүчний үйлдвэрлэл хангамж	- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх - Эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх - Хатуу түлш солих	Дараах усан цэнэгт цахилгаан станц (УЦЦС) барих төслийг хэрэгжүүлэх: - Сэлэнгэ аймаг, Жавхлант УЦЦС (100 МВт) - Хэнтий аймаг, Цэнхэрмандал УЦЦС (100 МВт)
Хөдөө аж ахуй	- Мал, түүний гаралтай бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулж, экспортыг нэмэгдүүлэх - Дотоодын зах зээлд мах нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	- Хонины мах, ноос экспортлох - Ямааны мах, ноолуур экспортлох - Адууны мах экспортлох
Аж үйлдвэр	- Цементийн үйлдвэрүүдийн хаягдал дулааныг ашиглах - Цементийн үйлдвэрлэлд нунтаг үнс ашиглах - Эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх - Эрчим хүчний хэрэглээний хэмнэлтийн менежментийг сайжруулах	- Цементийн үйлдвэрт нунтаг жонш ашиглах - CO ₂ ялган авч, газрын гүнд булшлах (CCS)
Барилга	- Ногоон орон сууцны барилга, эрчим хүчний хэмнэлттэй амины шинэ орон сууц барих - Сургууль, цэцэрлэгийн барилга, төсөвт байгууллагын барилгын дулаан техникийн шинэчлэл, Монгол гэрийн дулаан алдагдлыг бууруулах, халаалтын шинэчлэл, Угсармал орон сууцны барилгын дулаан техникийн шинэчлэл, Амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, халаалтын шинэчлэл хийх	Эрчим хүчний үр ашигтай, ногоон барилга, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх: - Ногоон барилга, ногоон орон сууц - 15-100 кВт усан халаалтын зуух шинэчлэх - Барилгын дулаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
Хог хаягдал	- Хог хаягдлыг дахин боловсруулах, дахивар нөөцийн хэрэглээг нэмэгдүүлэх - Төвлөрсөн хог хаягдлын цэгээс ялгарах метан хийг хоргүйжүүлэх - Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, өргөтгөх	- Бүсийн төвүүдэд дахин боловсруулах үйлдвэрүүд барих - 6-аас доошгүй аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих
Зам, тээвэр	- Евро-5 стандартын шатахуунд шилжих - Нүүрсний экспортын тээврийг төмөр замын тээвэрт шилжүүлэх - Цахилгаан автомашин болон нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх - Импортын автотээврийг төмөр замын тээвэрт шилжүүлэх	-
Бэлчээр	-	Бэлчээрийн улирлын сэлгээ нүүдлийг эрчимтэй хийх, доройтсон бэлчээрийг урт хугацаагаар өнжөөх, малын хөлийн ачааллыг зохицуулах уламжлалт арга технологийг үр дүнтэй хэрэгжүүлэн, ойт хээр, хээрийн доройтсон бэлчээрийн 10-аас доошгүй хувийг нөхөн сэргээж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нөхөн сайжруулах

Дасан зохицсон зорилт, арга хэмжээ

Монгол Улсын хувьд дасан зохицох зорилт, арга хэмжээг 8 салбарт тодорхойлсон байсан бол УТХН 3.0-д дараах 10 салбараар тодорхойлсон байна. Үүнд: 1) биологийн олон янз байдал 2) усны нөөц 3) ойн нөөц 4) гамшгаас хамгаалах 5) мал аж ахуй, бэлчээр 6) газар тариалан 7) нийгмийн эрүүл мэнд 8) Иргэдийн амьжиргаа, нийгмийн хамгаалал 9) Боловсрол 10) Соёлын салбар.

Бидэнтэй холбогдоорой

Батлагдсан зорилттой [ЭНД](#) дарж танилцана уу. Та бүхэнд энэхүү мэдээлэлтэй холбоотой аливаа асуух зүйл байвал бидэнтэй холбогдоорой.

www.pwc.com/mn

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ. Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.